



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 26-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

**“Ариг банк” ХХК-аас зээл авах зөвшөөрөл олгох,
холбогдох хэлцлүүдийг байгуулах зөвшөөрөл олгох тухай**

“Говь” ХК нь ноолуур бэлтгэлийн эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зорилгоор “Ариг банк” ХХК-аас зээл авах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь хэсэг, “Говь” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.7.14 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. “Говь” ХК нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны 03 сарын 20-ны өдрийн 01/912 тоот албан бичгийн хавсралтын дагуу “2023 оны ноолуур бэлтгэлийн зээлд оролцох хүсэлт ирүүлсэн ноолуур хялгас болон түүнээс дээш дамжлагатай үйлдвэр бүхий аж ахуйн нэгжийн жагсаалт”-д орсон бөгөөд ноолуурын бэлтгэлийн эргэлтийн хөрөнгийн санхүүжилт авах шаардлага үүссэнтэй холбогдуулан “Ариг банк” ХХК-аас 14,500,000,000 (арван дөрвөн тэрбум таван зуун сая) төгрөгийн “Ноолуур бэлтгэлийн зээл”-ийг жилийн 5%-ийн хүүтэй, 12 сарын хугацаатайгаар авахыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д зөвшөөрсүгэй.

Хоёр. “Ариг банк” ХХК-аас авах 14,500,000,000 (арван дөрвөн тэрбум таван зуун сая) төгрөгийн зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд барьцаалуулах хөрөнгийн жагсаалтыг энэхүү тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.

Гурав. Зээлийн гэрээ, Барьцааны гэрээ, бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг тус компанийн Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д олгосугай.

ТУЗ-ийн ДАРГА:

“ГОВЬ”
ХУВЬЦААТ КОМПАНИ

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн ГИШҮҮД:

ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ

Ц.БААТАРСАЙХАН

Б.АМАРСАЙХАН

Ц.ОРГИЛБОЛД

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЗО САВАДА

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

“Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2023 оны 06 сарын 26 -ний өдрийн хурлын
18.-р тогтоолын ... дүгээр хавсралт



“Ариг банк” ХХК-д барьцаалах хөрөнгө

№	Барьцаа хөрөнгө	Үнийн дүн /төгрөг/
1	Говь ХК-ийн бараа материал	4,000,000,000 /дөрвөн тэрбум/
2	Таван Богд ХХК-ийн Ариг банканд хадгалуулах мөнгөн хөрөнгө	15,000,000,000 /арван таван тэрбум/
	Нийт	19,000,000,000 /арван есөн тэрбум/